



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хангай сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/9/СТА-ТТЗ

<p>Хаяг: Архангай аймаг, Эрдэнэбулган сум. Аймгийн ЗДТГ-ын байр “А” корпус, 3 давхар зүүн жигүүр.</p> <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр Утас: 70333141 Цахим хаяг: UlambayarD@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Байгалмаа Утас: 70332860 Цахим хаяг: BaigalmaaT@audit.gov.mn</p> <p>Аудитор: В.Цогжаргал Утас: Цахим хаяг: TsogjargalB@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын код: АРА-2021/15/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.3 Авлага.....	12
3.5.6 Бараа материал	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	14
3.5.10 Орлогын данс	14
3.5.11 Зардлын данс.....	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7 Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	19
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
4. Менежментийн захидал.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2021.03.31 № 148

танай _____-ны № _____-т

ХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.ӨРНӨХБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хангай сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангай сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсөв захирагч нь нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	653,915.8	888,532.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,300.7	262,364.5
33	АВЛАГА	359,121.3	316,774.4
35	БАРАА МАТЕРИАЛ	182,493.8	294,901.0
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	14,492.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,989,342.7	7,397,115.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,989,342.7	7,397,115.6
39200	Биет хөрөнгө	6,897,380.5	7,303,015.9
39300	Биет бус хөрөнгө	79,212.2	78,349.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	12,750.0	15,750.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,643,258.6	8,285,647.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	31.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	31.0
41300	Өглөг	0.0	31.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,643,258.6	8,285,616.6
51	Засгийн газрын хувь оролцоо	7,643,258.6	8,285,616.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,828,272.4	1,828,272.4
51200	Хуримтлагдсан үр дүн	5,203,782.0	5,846,140.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	611,204.2	611,204.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,643,258.6	8,285,647.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,269,892.9	3,096,704.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	68,064.1	77,938.0
110	Орлогын албан татвар	47,081.7	53,160.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	47,081.7	53,160.0
113	Хөрөнгийн албан татвар	4,049.5	3,240.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,932.9	21,538.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	734,013.8	750,420.6
120	Нийтлэг татварын бус орлого	734,013.8	750,420.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,467,815.0	2,268,346.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,540,587.4	2,358,954.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,540,587.4	2,358,954.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,936,769.4	2,265,271.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,923.0	1,520,257.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,544.5	206,172.4

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,733.9	92,350.4
2104	Хангамж, бараа материалын зардал	109,604.6	74,760.5
2105	Нормативт зардал	74,226.6	65,471.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,466.2	9,992.0
2107	Томилолт, зочны зардал	16,141.6	10,446.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,323.5	52,189.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,805.6	233,631.5
212	ТАТААС	0.0	3,443.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	603,818.0	90,239.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	729,305.6	737,750.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	98,046.1	95,392.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	631,259.4	642,358.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,600,933.4	2,451,404.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	68,064.1	77,938.0
110	Орлогын албан татвар	47,081.7	53,160.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	47,081.7	53,160.0
113	Хөрөнгийн албан татвар	4,049.5	3,240.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,932.9	21,538.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,583.0	10,126.4
1181	Газрын төлбөр	416.0	2,127.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	10,933.9	9,284.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,054.3	105,120.5
120	Нийтлэг татварын бус орлого	65,054.3	105,120.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,467,815.0	2,268,346.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,395,225.2	2,195,466.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,395,225.2	2,195,466.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,791,119.6	2,101,820.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,254,589.0	1,523,013.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,883.4	202,716.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,826.0	94,940.8
2104	Хангамж, бараа материалын зардал	92,280.3	71,314.5
2105	Нормативт зардал	79,752.6	70,420.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,982.2	21,842.0
2107	Томилолт, зочны зардал	16,141.6	10,446.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,104.5	63,456.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,560.1	43,670.1
212	ТАТААС	0.0	3,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	604,105.6	90,246.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	205,708.1	255,938.5

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	247,426.0	60,874.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	247,426.0	60,874.7
2200	Дотоод эх үүсвэрээр	247,426.0	60,874.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(247,426.0)	(60,874.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(44,000.0)	(45,000.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	44,000.0	45,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(85,717.9)	150,063.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	198,018.7	112,300.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,300.7	262,364.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,011,999.1	7,011,999.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,011,999.1	7,011,999.1
9	Тайлант үеийн үр дүн	631,259.4	631,259.4
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,643,258.6	7,643,258.6
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,643,258.6	7,643,258.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,643,258.6	7,643,258.6
19	Тайлант үеийн үр дүн	642,358.0	642,358.0
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,285,616.6	8,285,616.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,480,355.8	2,270,816.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,226,650.6	2,179,766.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,141,389.4	2,101,478.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,523,217.6	1,523,013.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,854.8	202,716.0

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,930.1	94,340.8
2104	Хангамж, бараа материалын зардал	78,763.1	71,147.3
2105	Нормативт зардал	80,132.2	66,912.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,501.1	25,813.0
2107	Томилолт, зочны зардал	10,446.6	10,446.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,315.3	59,608.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,228.6	47,480.8
	ТАТААС	3,500.0	3,400.0
	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,500.0	3,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,761.2	74,887.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,761.2	74,887.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	156,205.2	46,050.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	97,500.0	45,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,480,355.8	2,392,559.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,527,144.6	1,507,209.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	743,367.4	755,777.6
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,000.0	32,607.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	175,843.8	96,964.9
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	74,703.5
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	196,446.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	130.5	130.5
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	608	608
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	381	381
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	227	227
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	130.5	130.5

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,165.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,165.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,165.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	600.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,210.2
2105	Нормативт зардал	3,507.9

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,847.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,165.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,165.9

Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хангай сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Д.Өрнөхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн сум хөгжүүлэх сангийн авлагыг бууруулахад тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 20-аас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор В.Цогжаргал гүйцэтгэв.

Хангай сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хангай сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхэм зорилго нь “Өөрийн боловсон хүчин, нутгийн иргэдийн оюуны болон материаллаг хүчин зүйлсийн бүхий л давуу тал нөөц бололцоонд тулгуурлан хүний хөгжлийг эрхэмлэх, байгаль орныхоо онцлогт зохицсон өөрийгөө тэтгэдэг оновчтой бүтэц бүхий эдийн засагтай хүн амын ажиллаж амьдрах таатай орчинтой загвар сум болох”-д оршино.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хангай сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Хангай сумын удирдлагын байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах зарчим алдагдах зэрэг үр дагавартай байна.

Хангай сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Төсвийн шууд

захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

Хангай сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг эс тооцвол дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,975,824.3 мянган төгрөгийн 1 хувь буюу **29,758.2** мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд хоорондын тооцоо нийлж устгах бичилт хийсэн цэвэр дүн буюу 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,454,346.6 мянган төгрөгийн 1 хувь буюу **24,543.5** мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл **112,300.7** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **262,364.5** мянган төгрөг болж, **150,063.8** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Төрийн сангийн харилцах	112,300.70	262,364.50	150,063.80
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	112,300.70	262,364.50	150,063.80
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Сум хөгжүүлэх сан	39,056.90	71,791.40	32,734.50
Орон нутгийн ерөнхий орлого	37,597.20	65,917.90	28,320.70
Орон нутгийн хөгжлийн сан	35,646.60	124,655.20	89,008.60
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	112,300.70	262,364.50	150,063.80

Эх сурвалж: Хангай сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө нь нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн 3 ажил бүрэн хэрэгжиж, 1 ажил дутуу, 4 ажил огт хэрэгжээгүйгээс 106,405.2 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй, өмнөх оны СТА-аар ОНХС-тай холбоотой зөрчилд өгсөн албан шаардлагын дагуу 18,250.0 мянган төгрөг төвлөрч нийт үлдэгдэл 124,655.2 мянган төгрөг, мөн сум хөгжүүлэх сан 71,791.3 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын данс 65,917.9 мянган төгрөгийн нийт 262,364.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 359,121.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 316,774.4 мянган төгрөгийг тайланд тусгасан ба авлага 42,346.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Байгууллагаас авах авлага	1426.80	1,426.80	0.00
Хувь хүмүүсээс авах авлага	357,694.50	315,347.60	(42,346.90)
Дүн	359,121.30	316,774.40	(42,346.90)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Орон нутгийн ерөнхий орлого	1426.8	1,426.80	0.00
Сум хөгжүүлэх сан	285,694.50	261,597.60	(24,096.90)
Орон нутгийн хөгжлийн сан	72,000.00	53,750.00	(18,250.00)
Дүн	359,121.30	316,774.40	(42,346.90)

Эх сурвалж: Хангай сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын данс 316,774.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага 261,597.6 мянган төгрөг, өмнөх оны СТА-аар ОНХС-тай холбоотой 72,000.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлагын үлдэгдэл 53,750.0 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 2005 онд сум хөгжүүлэх сангаас олгосон 1 иргэнтэй холбоотой, 1,426.8 мянган төгрөгийн авлага нь 2005 онд үүссэн эзэн холбогдогч нь нас барсан авлага байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 182,493.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 294,901.0 мянган төгрөг болж 112,407.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	55,559.90	115,956.70	60,396.80
Эм боох материал	9,309.70	38,217.70	28,908.00
Бичиг хэргийн материал	21,355.70	18,046.80	(3,308.90)
Аж ахуйн материал	80,270.30	103,019.80	22,749.50
Түлш шатах тослох материал	7,268.20	8,031.80	763.60
Барилгын засварын материал	581.80	3,889.10	3,307.30
Хүнсний материал	5,998.20	5539.1	(459.10)
Мал амьтад	2,150.00	2,200.00	50.00
Дүн	182,493.80	294,901.00	112,407.20
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Ерөнхий боловсролын сургууль	56,315.50	116,826.80	60,511.30
ЗДТГ	27,950.30	29,726.90	1,776.60
ИТХ	3,023.10	2,866.60	(156.50)
Соёлын төв	14,684.70	18,891.60	4,206.90
Хүүхдийн цэцэрлэг	43,840.60	57,604.60	13,764.00
Эрүүл мэндийн төв	36,679.60	68,984.50	32,304.90
Дүн	182,493.80	294,901.00	112,407.20

Эх сурвалж: Хангай сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 39.6 хувь буюу 116,826.8 мянган төгрөгийг ерөнхий боловсролын сургууль, 10.1 хувь буюу 29,726.9 мянган төгрөгийг ЗДТГ, 1.0 хувь буюу 2,866.6 мянган төгрөгийг ИТХ, 6.4 хувь буюу 18,891.6 мянган төгрөгийг Соёлын төв, 19.5 хувь буюу 57,604.6 мянган төгрөгийг хүүхдийн цэцэрлэг, 23.4 хувь буюу 68,984.5 мянган төгрөгийн бараа материалыг ЭМТ эзлэж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 283,879.6 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 94,244.9 мянган төгрөг, малын нас дэвшилттэй холбоотой 36,226.4 мянган төгрөг нийт 414,350.9 мянган төгрөгөөр нэмэгдэж үйл ажиллагаанд зарцуулсан 274,907.8 мянган төгрөг, шилжүүлсэн 3,777.8 мянган төгрөг, бусад 8,766.0 мянган төгрөг нийт 287,451.6 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Тус сумын ЗДТГ-т тайлант жилд 14,492.0 мянган төгрөгийн нөөцийн бараа бүртгэлтэй байгаа нь өвөлжилтийн бэлэн байдлыг хангаж ажиллахтай холбогдсон аймгийн засаг шийдвэрийн дагуу бүрдүүлсэн өвс, хорголжин тэжээлийн нөөцийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалтай холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

- Хангай сумын ЭМТ- Аудитын тайлангийн хугацаанаас хойш бараа материалын тайланд 8,886.7 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийг орлогод авч тайланд залруулга хийгдсэн болно.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,989,342.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7,397,115.6 төгрөг болж 407,772.9 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн 98.9 хувийг биет хөрөнгө, 1.1 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна..

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,897,380.40	7,303,015.80	405,635.4
Биет бус хөрөнгө	79,212.30	78,349.80	(862.50)
Бусад хөрөнгө	12,750.00	15,750.00	3,000.0
Дүн	6,989,342.70	7,397,115.6	407,772.9
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Засаг даргын тамгын газар	1,343,138.2	1,467,281.9	124,143.7
Ерөнхий боловсролын сургууль	4,169,734.4	4,318,995.3	149,260.9
Эрүүл мэндийн төв	456,739.9	577,756.4	121,016.5
Соёлын төв	539,984.4	523,077.1	(16,907.3)
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	161,865.6	157,591.6	(4,274.0)
Хүүхдийн цэцэрлэг	317,880.2	352,413.3	34,533.1
Дүн	6,989,342.7	7,397,115.6	407,772.9

Эх сурвалж: Хангай сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 58.4 хувь буюу 4,318,995.3 мянган төгрөгийг ерөнхий боловсролын сургууль, 19.8 хувь буюу 1,467,281.9 мянган төгрөгийг ЗДТГ, 7.8 хувь буюу 577,756.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн төв, 7.1 хувь буюу 523,077.1 мянган төгрөгийг Соёлын төв, 2.1 хувь буюу 157,591.6 мянган төгрөгийг ИТХ, 4.7 хувь 352,413.3 мянган төгрөгийг Хүүхдийн цэцэрлэг тус тус эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 17,824.7 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 599,288.7 мянган төгрөг, шилжүүлэн авсан 4,012.0 мянган төгрөг нийт 621,125.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталж устгасан 2,313.2 мянган төгрөг, шилжүүлсэн 3,000.0 мянган төгрөг нийт 5,313.2 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Хангай сумын ЕБС- БШУЯ-аас Элэгдлээ бүрэн нөхсөн 1193ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн цаашид ашиглагдах боломжит хугацаа болон холбогдох нөхцөлийг хэлэлцүүлэх зөвлөмж хүргүүлээ.

3.5.5 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 31.0 мянган төгрөг байгаа Соёлын төвийн Буман үсэг ХХК-д төлөх бичиг хэргийн өр байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,643,258.6 мянга, эцсийн үлдэгдэл 8,285,616.6 мянган төгрөг болж, 642,358.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Засгийн газрын хувь оролцоо /мян. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	1,828,272.4	1,828,272.4	0.0
Хуримтлагдсан үр дүн	5,203,782.0	5,846,140.0	642,358.0
Хөрөнгийн дахин үнэлгээний	611,204.2	611,204.2	0.0
Дүн	7,643,258.6	8,285,616.6	642,358.0

Эх сурвалж: Хангай сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 642,358.0 мянган төгрөгөөр өсч тайлагнагдсан байна.

3.5.7 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 77,938.0 мянган төгрөгийн татварын орлого, 750,420.6 мянган төгрөгийн татварын бус орлого, 2,268,346.0 мянган төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,096,704.6 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнагдсан байна. Тусламж санхүүжилтийн орлогын 1,522,092.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,165.9 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоос, 698,480.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32,607.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Санхүүгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны зардал 2,358,954.4 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 95,392.2 мянган төгрөг, нийт 2,454,346.6 мянган төгрөгийн зардал тайлагнасан байна. Үйл ажиллагааны нийт үр дүн өмнөх оноос 11,098.6 мянган төгрөгөөр өссөн нь татварын бус орлого өссөнтэй холбоотой байна.

Тайлант онд 521,477.6 мянган төгрөгийн давхардсан гүйлгээг устгах бичилт хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Хангай сумын ЭМТ- ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хөнгөлөлт тооцох хэмжээг тухайн саруудад зарим албан хаагчдын цалингаас зөрүүтэй тооцсон зөрчилд зөвлөмж хүргүүлээ.
- Хангай сумын ЭМТ- Норматив зардлаас 300.0 мянган төгрөгийн бэлэг авч зардлыг зориулалт бус зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Хангай сумын ЕБС- Цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй 24,791.0 мянган төгрөгийн анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.
- Хангай сумын Соёлын төв- Ажилчдад цалин болон үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон 1433.6 мянган төгрөгийн зөрчид төлбөрийн акт тогтоолоо.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Хангай сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны орон нутгийн ерөнхий орлогыг 40,337.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн орлогын төсвийн төслийг Сумын ИТХ-ийн 2019 оны 12 сарын 13-ны өдрийн 10 тоот тогтоолоор 4,849.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 45,186.9 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг 45,186.9 мянган төгрөгөөр тодотгон баталж, гүйцэтгэлээр 85,973.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлж, төлөвлөгөөг 190.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 6. Төвлөрүүлэх орлого /мян.төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	1,200.0	1,504.0	304.0	125.3
2	Шууд бус орлого	7,600.0	24,613.4	17,013.4	323.8
3	Хадгаламжийн хүүгийн орлого	16,800.0	24,672.6	7,872.6	146.9
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	100.0	2,370.0	2,270.0	2,370.0
5	Бууны татварын орлого	4,050.0	3,240.0	(810.0)	80.0
6	Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	2,660.0	888.8	(1,771.2)	33.4
7	Газрын төлбөр		14.8	14.8	100.0

8	Газрын дуудлага худалдааны орлого	415.0	2,112.4	1,697.4	509.0
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,090.0	8,216.2	7,126.2	753.8
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,200.0	1,021.4	(178.6)	85.1
11	Байгалийн ургамал ашигласны төлбөр	78.5	245.0	166.5	312.1
12	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	800.0	1,050.0	250.0	131.2
13	Ойн нөөц ашигласны төлбөр	7,825.4	7,767.4	(58.0)	99.3
14	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	68.0	222.0	154.0	326.5
15	Төсөвт байгууллагын өөрийн орлого	300.0	355.0	55.0	118.3
16	Хүү торгуулийн орлого	600.0	4,782.7	4,182.7	797.1
17	Нэр заагдаагүй бусад орлого	400.0	2,897.5	2,497.5	724.4
Дүн		45,186.9	85,973.2	40,786.3	190.3

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч дараах 4 нэр төрлийн орлого 2,817.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Зарим галт зэвсэг эзэмшигч тодорхойгүй, иргэд хоорондоо худалдах, шилжүүлэх, ашиглах боломжгүй болсон зэрэг шалтгаанаар шинэчилсэн бүртгэл хийгдээгүйтэй холбоотой бууны татварын орлого 810.0 мянган төгрөгөөр
2. Хураамжийн орлого аймгийн ерөнхий орлогын дансанд төвлөрдөг болсонтой холбоотой улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,771.2 мянган төгрөгөөр
3. Цар тахалтай холбоотой хог хаягдлын үйлчилгээний хураамж 178.6 мянга, ойн нөөц ашигласны төлбөр 58.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын анхны болон тодотгосон төсөв батлах тухай тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 7. ИТХ-ын тогтоол /мян.төгрөг/

№	Санхүүжүүлэх эх үүсвэр	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Орон нутгийн ерөнхий орлого	42,713.5	44,886.9	2,173.4
2	Төсөвт байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	102,600.0	102,600.0	0.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	424,212.6	413,806.9	(10,405.7)
4	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	116,771.5	113,808.6	(2,962.9)
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	1,732,454.9	1,732,209.6	(245.3)
6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	23,222.0	37,597.3	14,375.3
7	Урьд оны ОНХС-ийн үлдэгдлээс санхүүжих	34,346.6	35,646.7	1,300.1
Нийт дүн		2,476,321.1	2,480,556.0	4,234.9

Байгууллагын нэр				
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	65,243.0	68,243.0	3,000.0
2	Засаг даргын тамгын газар	425,205.1	428,348.1	3,143.0
3	Орон нутгийн хөгжлийн сан	151,118.1	149,455.3	(1,662.8)
4	Сум хөгжүүлэх сан	100,000.0	100,000.0	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	311,106.8	279,593.7	(31,513.1)
6	Ерөнхий боловсролын сургууль	866,046.7	898,468.8	32,4222.1
7	Соёлын төв	75,070.1	75,070.1	0.0
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	482,531.3	481,377.0	(1,154.3)
Нийт дүн		2,476,321.1	2,480,556.0	4,234.9

Ноос ноолуур, арьс ширний урамшууллаас орсон орлогын хагас жилийн гүйцэтгэлд үндэслэн шууд бус орлогыг нэмж баталсанаас ерөнхий орлогыг 2,173.4 мянга, мөн урьд оны үлдэгдлийг 15,675.4 мянган төгрөгөөр нэмж тодотгосон бол орон нутгийн удирдлагын байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 10,405.7 мянга, сумын ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 2,962.9 мянга, ковид-19 цар тахалтай холбоотой боловсролын байгууллагын үдийн цай хоолны зардлаас 245.3 мянган төгрөгийг хасаж тодотгосон байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ЕБС-ийн нийт зардлыг 3,000.0 мянган төгрөгөөр бууруулж, Хүүхдийн цэцэрлэгийн нийт зардлыг 2,800.0 мянган төгрөгөөр нэмж баталж сумын нийт зардлыг 2,480,355.8 мянган төгрөгөөр баталсан нь ковид-19 цар тахлын улмаас хэмнэгдэж байгаа сургуулийн хүүхдийн үдийн хоол, цайны зардлын санхүүжилтээс Сангийн яам төсөвт зохицуулалт хийн буцаан татсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,480,355.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,226,650.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 156,205.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 97,500.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,527,144.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 743,367.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 34,000.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 102,300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 300.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 73,243.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 78,414.9 мянган төгрөг, төлөвлөөгүй өмнөх СТА-аар илэрсэн ОНХС-тай холбоотой албан шаардлагын дагуу 18,250.0 мянган төгрөг нийт 96,664.9 мянган төгрөг бүрдүүлж, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 78 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,270,816.7 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь урсгал зардал 46,883.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, хөрөнгийн зардал 110,155.2 мянган төгрөг зарцуулагдаагүй, 52,500.0 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн зээлийг төлөвлөсөн хэмжээнээс дутуу олгосонтой холбоотой байна.

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас буюу сумын Ахмадын хороонд 3,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож гүйцэтгэлээр 3,400.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 13,460.0 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандит тусламжаар 1,705.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж урсгал зардалд зарцуулсан байна.

ОНХС болон СХС-ийн талаар

- ✓ Сумын ИТХ-ын хурлын 2020 оны 09 сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 8 хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 149,455.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Гүйцэтгэлээр 3 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийх ажил дутуу хэрэгжиж, 4 ажил огт хэрэгжээгүйгээс 106,405.2 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй, өмнөх оны СТА-аар ОНХС-тай холбоотой зөрчилд өгсөн албан шаардлагын дагуу 18,250.0 мянган төгрөг төвлөрч нийт үлдэгдэл 124,655.2 мянган төгрөг байна.
- ✓ Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 100,000.0 мянга, олгох зээлийг 97,500.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 69,096.9 мянган төгрөгийн үндсэн зээл, 8,963.0 мянган төгрөгийн хүүгийн орлого төвлөрч, 45,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

Нийт 261,597.5 мянган төгрөгийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 81,143.7 мянган төгрөг буюу 31.0 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 45,283.0 мянган төгрөг буюу 17.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 135,170.8 мянган төгрөг буюу 51.7 хувь нь чанаргүй зээл байна.

Аудитаас 180,453.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдлийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүллээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 47 мэдээллээс 42 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 302,447.0 мянган төгрөгийн сум хөгжүүлэх сангийн авлагатай холбоотой зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	215,747.0					50.0
Албан шаардлага	2	77,383.3	1	23,633.3	1	53,750.0	30.5
Нийт	1	293,130.3	1	23,633.3	1	53,750.0	40.3

Орон нутгийн ерөнхий орлоготой холбоотой 5,383.3 мянган төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлт бүрэн хангагдсан бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангийн 72,000.0 мянган төгрөгийг 24 малчин өрхөд 3 жилийн хугацаатай зээл олгосон зөрчилд өгсөн албан шаардлагын дагуу 18,250.0 төвлөрч 53,750.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа тул шийдвэрийн биелэлтийг 30.5 хувьтай гэж үзлээ. СХС-ийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч 180,453.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байгаа тул шийдвэрийн биелэлтийг 50 хувьтай байна гэж үзлээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 9. Санал дүгнэлтийн хэлбэр

№	Байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр			
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Засаг даргын тамгын газар	1			
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1			
3	Ерөнхий боловсролын сургууль	1			
4	Хүүхдийн цэцэрлэг	1			
5	Эрүүл мэндийн төв	1			
6	Соёлын төв		1		
7	Орон нутгийн хөгжлийн сан		1		
8	Сум хөгжүүлэх сан		1		
	Дүн	5	3		

Аудитаас дээрх 4 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 701,979.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,886.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 20,285.0 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 665,641.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмж хүргүүлж, 7,166.4 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоолоо. Үүнийг төсвийн шууд болон ерөнхийлөн захирагчаар ангилан харуулбал:

Нэг. Төсвийн шууд захирагчдын СТА-ын дүнгийн талаар

Төсвийн шууд захирагчдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **519,052.6** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 8,886.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 485,187.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 17,811.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7,166.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

Хүснэгт 10. ТШЗ-ийн зөрчлийн нэгтгэл /мян.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс:						
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага		Акт		Залруулсан
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	ЕБС	3	24,791.0	3	24,791.0					
2	Хүүхдийн цэцэрлэг	4	54,204.0	2	33,763.1	1	16,767.5	1	3,673.4	
3	ЗДТГ	5	285,978.1	3	284,934.0	2	1,044.1			
4	ИТХурал	2	6,247.4	2	6,247.4					
5	Эрүүл мэндийн төв	7	146,398.5	4	135,452.4			2	2,059.4	8,886.7
6	Соёлын төв	1	1,433.6					1	1,433.6	
	ДҮН	22	519,052.6	14	485,187.9	3	17,811.6	4	7,166.4	8,886.7

Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн СТА-ын дүнгийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 182,927.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 180,453.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж, 2,473.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Хүснэгт 11. ТЕЗ-ийн зөрчлийн нэгтгэл /мян.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Зөвлөмж		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэгтгэсэн тайлан	2	2,473.4			2	2,473.4
2	СХС	1	180,453.8	1	180,453.8		
	ДҮН	3	182,927.2	1	180,453.8	2	2,473.4

Сумын ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Орон нутгийн төсвийн 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 1,046.6 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

2. Орон нутгийн ерөнхий орлогын дансанд бүртгэлтэй олон жилийн насжилттай эзэн холбогдоггүй 1,426.8 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

Сумын ерөнхийлөн захирагчид СХС-ийн 180,453.8 мянган төгрөгийн авлагатай холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тухайн байгууллагын хувьд балансын дараа Соёлын төвийн 31.0 мянган төгрөгийн өр төлбөр барагдсан байна.

Дараагийн аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргасан эсэхийг авч үзэх нь зүйтэй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ


Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас олгосон 180,453.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.
- 1.2. Эрсдэл: Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй цаашилбал сангийн хөрөнгийн эх үүсвэр дутагдаж, зээлийн ашиглалтаас бий болох үр нөлөө буурах болно.
- 1.3. Өгсөн зөвлөмж Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Сумдын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2021 он			АРА-2021/1/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хангай сумын ТЕЗ-ийн 2020 оны СТА		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Орон нутгийн төсвийн 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 1,184.4 мянган төгрөгөөр тасарсан байна.	1,184.4	Албан шаардлага өгөх	Засаг дарга, САД	Д.Өрнөхбаяр Ш.Шугаржав
2	Сум хөгжүүлэх сангийн нийт 261,597.5 мянган зээлийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнээс 180,453.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна.	180,453.8	Зөвлөмж өгөх	Засаг дарга, САД	Д.Өрнөхбаяр Ш.Шугаржав
3	Орон нутгийн ерөнхий орлогын дансанд бүртгэлтэй олон жилийн насжилттай эзэн холбогдогчгүй 1,426.8 мянган төгрөгийн авлага байна.	1,426.8	Албан шаардлага өгөх	Засаг дарга, САД	Д.Өрнөхбаяр Ш.Шугаржав
	Дүн	183,065.0			